

ТЭРГҮҮН

КРАСНОЯРСК: ЗӨВЛӨЛТИЙН ШИНЭ САНААЧИЛГА

ЗХУКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга М. С. Горбачев 1988 оны 9-р сард Красноярскд хэлсэн үгэндээ дэлхийн хамгийн том тив бөгөөд түүхийнхээ эргэлтийн шатанд ороод байгаа Ази, Номхон далайн бүс нутагт цэрэг зэвсгийн сэргэлдөөнийг багасгах, зөрөлдөөн бүхий голомт цэгүүдийг арилгах, энх амгалан байдлыг сахин хамгаалахад чиглэсэн арга замыг зааж өглөө. Энэ бол улс төрийн шинэ сэтгэлгээний яруу тод жишээ мөн.

ЗСБНХУ болон социалист бусад орноос явуулж байгаа улс төрийн шинэ сэтгэлгээнд тулгуурласан идэвхтэй, тууштай үйл ажиллагаа, дэвшилт бүхий хүчний шаргуу тэмцлийн үрээр Ази тивийн байдлыг тогтвортой болгох замд шинэ алхам, шинэ хандлага гарсаар байна. Сүүлийн үед бүс нутгийн янз бүрийн район дахь хямрал, мөргөлдөөнийг зохицуулах талаар нааштай алхмууд гарлаа. Афганистаны эргэн тойрны байдлыг улс төрийн аргаар зохицуулах тухай Женевийн хэлэлцээрт гарын үсэг зурж, Иран, Иракийн цуст мөргөлдөөнийг зогсоох замд ахиц гарч, НҮБ-ын ерөнхий нарийн бичгийн даргын оролцоотой хэлэлцээ хийж байгаа нь бүс нутгийн байдлыг эрүүлжүүлэх, ужиг хямрал, дайныг зогсоох боломжийг нээж байна. Зүүн өмнөд Азийн байдалд сайн тийш өөрчлөлт гарч, Кампучийн асуудлыг эв зүйгээр шийдвэрлэх чиглэлд бодитой алхам хийж байна.

Үнэхээр энэ асар их өргөн уудам нутагт эрүүл саруулаар сэтгэгч хүчин идэвхжиж, сэргэлдөөн мөргөлдөөнгүй байхыг эрмэлзэн, цаашдын их ирээдүйтэй үйл явц өрнөж байгаа нь бүс нутгийн төдийгүй дэлхий нийтийн анхаарлыг өөрийн зүг зүй ёсоор татаж байна. Энэ бүс нутгийн байдлыг сайжруулах хамгийн гол арга зам бол түгшүүртэй байдлыг намжааж, зэвсэглэлээр хөөцөлдөхийг зогсоож зэвсэглэлийг юуны өмнө цөмийн зэвсгийг хорогдуулах, хүчээр сүрдүүлэх бодлогыг орхих, улс орнуудын цэргийн бодлогод өөрчлөлт оруулах явдал мөн гэдгийг улам олон хүн ойлгох болж байна.

НҮБ, эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн, олон улсын бусад байгууллагын үйл ажиллагаа Ази тийш хандаж байна. Манай нийслэл Улаанбаатарт гэхэд л Ази, Номхон далайн бүс нутгийн аюулгүй байдал, эдийн засгийн хамтын ажиллагааны асуудлаар олон улсын олон хурал чуулга болж өнгөрлөө. Жишээ нь, монгол-америкийн эрдэмтдийн бага хурал, Ази, Номхон далайн бүс нутгийн улсуудын олон нийтийн төлөөлөгчдийн чуулга уулзалт НҮБ-ыг дэмжих нийгэмлэгүүдийн дэлхийн холбооны Азийн бүсийн II бага хурал, социалист орнуудын дорно дахин судлаачдын эрдэм шинжилгээний бага хурал зэргийг нэрлэж болно. Эдгээр олон улсын чуулга уулзалт дээр Ази, Номхон далайн бүс нутгийн улс түмний хүч чармайлтыг энх тайвнаар хамтран ажиллах чигт дайчлан эрчимжүүлэхийг чухал гэж үзэв.

Дэлхийн бөмбөрцгийн энэ бүс нутгийн аюулгүй байдлыг бэхжүүлэх үйлсэд ЗСБНХУ-ын явуулж ирсэн чиглэсэн зорилготой, уян хатан гадаад бодлого жинтэй хувь нэмэр оруулж байна. Одоогоос хоёр жилийн

өмнө Владивосток хотноо ЗХУКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга М. С. Горбачев Ази, Номхон далайн улс орнуудын харилцааг өөрчлөх өргөн хүрээтэй программ дэвшүүлсэн нь дэлхийн олон нийтийн халуун дэмжлэгийг хүлээсэн билээ.

Ази, Номхон далайн бүс нутгийн улс төрийн байдлыг сайн тийш өөрчилж урагш жинтэй алхам хийх талаар уйгагүй чармайж байдгийн бас нэг тод нотолгоо нь Красноярскд 1988 оны 9-р сарын 16-нд нөхөр М. С. Горбачевын дэвшүүлсэн долоон зүйлт цогцолбор санал болж байна. Зөвлөлтийн шинэ санал нь Ази, Номхон далайн харилцан уялдаатай өнөөгийн бодит байдлыг тусгасан, бүс нутагт одоо оршиж байгаа ээдрээ түвэгтэй асуудлыг улс төрийн аргаар зохицуулахад чиглэсэн алсын ирээдүйтэй, сайн зүг тийш урагшлах бодитой программ мөн. Европт нэгэнт бий болсон намжмал байдлын үйл явцыг Ази тивд дэлгэрүүлж, Үүний тулд юуны өмнө бүс нутгийн хурцадмал байдлын үндэс болж байгаа зэвсгээр хөөцөлдөх, зэвсэглэх, хүчээр сүрдүүлэх бодлогыг таягдан хаяж, улс орнуудын цэргийн бодлогод эрчимтэй өөрчлөлт хийх замаар байдлыг эрүүлжүүлэх гэсэн эрмэлзэлд зөвлөлтийн шинэ саналын утга учир оршиж байна. Үнэхээр ч Ази, Номхон далайн сав нутагт учирч байгаа бэрхшээл, хурцадмал байдлын гол буруутан нь зэвсгээр, юуны өмнө цөмийн зэвсгээр хөөцөлдөх явдлыг энэ районд дэлгэрүүлэхийг улайран оролдож байгаа бүх милитарист харгис хүчин юм. Иймээс зөвлөлтийн удирдагч энэ бүс нутагт цөмийн ямарваа зэвсгийнхээ тоог нэмэгдүүлэхгүй байж, мөн ийм алхам хийхийг АНУ-д санал болгосон нь ЗСБНХУ асуудалд хичнээн гүнзгий, бодитой хандаж байгаагийн илрэл юм.

ЗСБНХУ-ын удирдагч агаарын болон тэнгэсийн цэргийн хүчнийг нэмэгдүүлэхгүй байж тэнцүү хэмжээгээр хорогдуулах, тэдгээрийн идэвхийг хязгаарлах зорилгоор Хятад, Япон, БНАСАУ, Өмнөд Солонгосын эргийн ойролцоо нутгуудад цэргийн сөрөг төвлөрлийг багасгах тухай олон этгээдийн хэлэлцээ хийхийг санал болголоо. Энэ хэсэг бүсийг сонгож авсан нь учиртай юм. Ази, Номхон далайн бүсэд байгаа агаарын болон тэнгэсийн цэргийн хүчний гол цөм нь дээрх орнуудын эрэг хавьд төвлөрч байна. Японд америкийн 50 мянга орчим цэргийн албан хаагч, 120 бааз, объект Өмнөд Солонгост 40 гаруй мянган цэргийн албан хаагч, олон арван бааз, түүгээр барахгүй цөмийн цэнэг тээх чадвартай Ланс пуужин, нейтроны бөмбөг байрлаж байна. Цөмийн зэвсэг тээсэн америкийн хөлөг онгоцууд Японы усан боомтод тус орны олон нийтийн эсэргүүцлийг үл хайхран чөлөөтэй нэвтэрсээр байна.

АНУ, Япон, Өмнөд Солонгосын цэргийн хамтарсан сургууль жилээс жилд олширч, хамрах хүрээ, оролцох зэвсэг, техник цэргийн тоо нэмэгдэж байгаа нь хөрш орнуудын төдийгүй нийт бүс нутгийн аюулгүй байдалд ноцтой занал учруулж байгаа билээ. Номхон далай, Энэтхэгийн далайд байрласан АНУ-ын тэнгэсийн цэргийн V, VII флотын үйл ажиллагаа нь манай тивийн улс түмний эсрэг шууд чиглэж байна.

Энэ бүгд нь Ази, Номхон далайн районд түгшүүртэй байдлыг намжааж, улс төрийн шинэ сэтгэлгээнд үндэслэсэн шинэ алхам хийхийг зүй ёсоор шаардаж байна. ЗХУКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга М. С. Горбачевын шинэ санал энэ үүднээс үнэхээр цаг үеэ олсон төдийгүй, бүс нутгийн бусад орны дэвшүүлсэн санал, санаачлагуудыг харгалзан үзсэн, тэдгээрийг ажил хэрэг болгоход чиглэсэн маш чухал алхам боллоо гэж монголын олон нийт өндөр үнэлж байна. Ази,

Номхон далайн аюулгүй байдалд хамаатай зөвлөлтийн болон бусад ямарваа саналыг авч хэлэлцэх хэлэлцээний механизм бий болгох тухай асуудлыг авч хэлэлцэхийг зөвлөлтийн удирдагч санал болгосноор БНМАУ-ын дэвшүүлсэн бүс нутгийн орнуудын харилцаанд хүч үл хэрэглэх механизм бий болгох, түүнчлэн Азийн өргөн олон нийтийн чуулга уулзалт хийх тухай санаачлагыг хэрэгжүүлэх сайхан төлөв нээж байна.

Ази, Номхон далайн аюулгүй байдлыг зэвсэглэлээр хөөцөлдөх замаар биш харин улс төр, эдийн засгийн өргөн хамтын ажиллагааг хөгжүүлж, дайсагнах, хардаж сэрдэх, үл итгэх байдлыг арилгаж, улмаар тус бүс нутгийн улс орнуудын харилцан уялдаатай ашиг сонирхлыг адил тэнцүү харгалзан үзэх замаар л хангаж болно.